



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАРТ НӨЛӨӨЛЖ БУЙ ХЯМРАЛ БА МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ

Д.Цолмонтаяа, оюутан

*Manchester College, UK, Уул Уурхайн Эдийн Засаг
Менежментийн мэргэжилтэн*

1. Монгол улсын уул уурхайн салбарын өнөөгийн байдал

Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр эрдэс түүхий эдийн үнэ ханшийн өсөлтөөс үүдэн уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж Монгол улсын эдийн засагт томоохон байр суурь эзлэх болсон.

Монгол улсын эдийн засагт дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2001 онд 1.1 триллион төгрөг байсан бол 2007 онд 4.5 триллион төгрөг болж 3.9 дахин өссөн мэдээ байна. Үүнийг дагаад уул уурхай, эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний ДНБ-нд эзлэх хувь 2002 онд 10.1% хувь байсан бол 2007 онд 27.5% болж даруй 2.5 дахин нэмэгдсэн байна.

Мөн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд эзлэх хувь сүүлийн 5 жилд огцом өсөж, өнөөдрийн байдлаар 80.7% ийг эзэлж байна.

Өнөөдрийн байдлаар уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүнд зэс, хайлуур жоншны баяжмал, нүүрс, алт томоохон байр суурь эзэлдэг. Уул уурхайн салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 200 гаруй аж ахуй нэгжийг байгааг ашигт малтмалын чиглэлээр ангилан харуулбал:

1. Зэс, молибден	– 3
2. Алт	– 127
3. Хайлуур жонш	– 44
4. Нүүрс	– 28
5. Газрын тос	– 5

Манай улсын төсвийн 70% орчим хувийг зөвхөн алт, зэс олборлодог компаниудын татварын хувиар бүрдүүлдэг бөгөөд үүний 70-аас илүү хувийг сүүлийн 30 жил турш Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт” УБҮ (зэс-молибдений баяжмал) дангаараа бүрдүүлсээр иржээ.

Сүүлийн жилүүдэд эрдэс баялгийн салбарт судалгаа, шинжилгээ хайгуулын ажилд томоохон хөрөнгө оруулалт хийгдэж байна. Жилдээ 62600 төгрөг /2004 онд/ зарцуулж байсан бол 2007 онд 280243 мян.төгрөг болон өссөн байна. Судалгаа шинжилгээ ажилд хөрөнгө зарахын хэрээр томоохон ордуудын нөөц нэмэгдэж шинэ ордууд нээгдэж байна. Нөөц нэмэгдэхийн хэрээр манай улсын энэ салбар гадаадын томоохон хөрөнгө оруулагчдын анхаарлыг зүй ёсоор татаж байна. Одоогоор манай улсад нээгдсэн хамгийн том орд болох Оюу толгойн зэс алтны ордыг ашиглахаар Их Британийн “Рио Тинто” болон Канадын “Айвенхоу Майнз” компани гэрээ хэлэлцээрийн шатандаа явж байгаа байна. Мөн “Таван Толгойн” коксжих нүүрсний ордод хөрөнгө оруулах сонирхолтой байгаагаа АНУ, ОХУ, БНХАУ, Канад, Япон, Энэтхэг зэрэг орнуудаас мэдэгдээд байгаа. Мөн “Асгат”-ын мөнгөний ордыг ашиглахаар ОХУ, “Төмөртэйн” төмрийн ордыг ашиглахаар ОХУ, Казакстаны засгийн газраас хүсэлт гаргасан байна.

2. Уул уурхайн салбарт төрөөс баримтлаж буй бодлого

Монгол Улсын Засгийн газар экспортын чиг хандлагатай үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд уул уурхайн салбарыг тус орны эдийн засгийн тэргүүлэх салбар болгон тодорхойлсон бөгөөд хөрөнгө оруулагчдад байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай, тэргүүний техник, технологи нэвтрүүлэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх таатай нөхцөл бүрдүүлэхийг чухалчилж байна.

Мөн түүнчлэн Монгол улсын засгийн 2008-2012 оны мөрийн хөтөлбөрт:

- Монгол орны нутаг дэвсгэрийн геологийн тогтоцыг үе шаттайгаар судлах
- Эрдэс баялагийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх
- Ашигт малтмалын томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцөлийг бүрдүүлэх
- Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулах
- Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангах. Экспортлох замаар Монгол улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилго тавин ажиллаж байна.

Үүнээс гадна зарим томоохон ажлуудыг хийж гүйцэтгэхээр тодрохой тусгасан байна. Үүнд:

- Ашигт малтмалын салбарын хөгжлийг түргэтгэж эрх зүйн орчныг шинэчлэх, ашигт малтмалын стратегийн болон томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг бодиттойгоор хэрэгжүүлж, орлогоос иргэдэд хүртээх;
- Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, уул уурхайн салбарт түшиглэсэн үйлдвэрлэл, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэхийн зэрэгцээ мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд онцгой анхаарах;

Энэ бодлогын хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ордуудыг ашиглалтанд оруулж эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхийг нэн тэргүүнд тавин цаашдын эдийн засгийн байдлаа тогтворжуулах боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.

2007 онд гаргасан УИХ-ийн 27 дугаар тогтоолоор стратегийн өндөр ач холбогдол бүхий ордуудын жагсаалтыг баталсан бөгөөд ашигт малтмалын хуулинд ч тодорхой заалтыг оруулсан байна. “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд гэж үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсхүл жилд Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг хэлнэ” гэж Ашигт малтмалын тухай хуулинд тодорхойлсон.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордууд

Ордын нэр	Ашигт малтмалын төрөл
1 Таван толгой	Нүүрс
2 Нарийн сухайт /ашиглаж байгаа/	Нүүрс
3 Багануур /ашиглаж байгаа/	Нүүрс
4 Шивээ овоо /ашиглаж байгаа/	Нүүрс
5 Мардай	Уран
6 Дорнод	Уран
7 Гурван булаг	Уран
8 Төмөртэй	Төмөр
9 Оюу Толгой	Алт, зэс
10 Цагаан сувага	Зэс, молибден
11 Эрдэнэт /ашиглаж байгаа/	Зэс, молибден
12 Бүрэнхаан	Фосфор
13 Бороо /ашиглаж байгаа/	Алт
14 Төмөртэйн Овоо /ашиглаж байгаа/	Төмөр
15 Асгат	Мөнгө

3. Санхүү, эдийн засгийн хямрлын уул уурхайн салбарт үзүүлэх нөлөөлөл

Өндөр хөгжилтэй АНУ-с үүдэлтэй гэх санхүүгийн хямрал монгол улс шиг түүхий эд капиталын зах зээлээс хамааралтай эдийн засагт дэлхийн санхүүгийн хямрал азийн санхүүгийн хямралын нэгэн адил нөлөө үзүүлэхгүй хэмээн эдийн засагч улстөрчид таамаглаж байлаа.

Гэтэл 2007 оныг хүртэл харьцангуй тогтвортой байсан алт, зэсний үнэ дэлхийн зах зээл дээр үнэ огцом унасан нь манай улс шиг төсвийнхөө 70% -ийг уул уурхайн бүтээгдэхүүний бүрдүүлдэг тэр тусмаа уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн татвараар төсвийнхөө дийлэнх хувийг бүрдүүлдэг Монгол улсын эдийн засагт хүчтэй нөлөөлж эхэлсэн ба тэр дундаа манай улсын төсвийн орлого, гадаад валютын нөөцөд хүчтэй нөлөө үзүүлсэн байна. Үүнээс үүдэлтэй энэ хямрал нь дотоодын эдийн засаг, худалдааны салбарын хямралыг улам гүнзгийрүүлээд байна. Зөвхөн өнгөрсөн онд л гэхэд энэ байдлаас үүдэн төсвийн орлого 57% хүртэл буурч төсвийн алдагдалд орсон тооцоо гарсан байна.

Яагаад тогтвортой байсан зэсийн үнэ унах болсон шалтгааныг Лондонгийн “ETF Securites” компанийн судалгааны албаны үзэж байгаагаар өнгөрсөн жил уул уурхайн компаниуд хүчин чадлаа бууруулж, санхүүжилтээ багасгасны улмаас зэсийн үнэ доод түвшиндээ хүрсэн гэж үзэж байна. Мөн зэсийн өндөр хэрэглээтэй болох хятадын түүхий эдийн хэрэглээ буурсан зэрэг нь үнэ суларахад нөлөөлсөн гэж үзэж байна.

Дэлхийн зэсийн түүхий эдийн зах зээл сулрах болсон шалтгааныг зэсийн түүхий эдийг боловсруулах зардал өссөн явдал гэж тодорхойлсон байдаг. Зэсийн баяжмалын шууд боловсруулах зардал өнгөрсөн онд 299 орчим ам.доллар байсан бол 1 дүгээр сарын байдлаар 60% орчимоор нэмэгдэж 477 орчим ам.доллар болсон байна. Энэ зардал цаашдаа ч өсөх хандлагатай байна. Үүнээс үүдэн Хятадын томоохон хайлах үйлдвэрүүд үйлдвэрлэлийнхээ хэмжээг багасгаж зарим үйлдвэрүүдийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон нь баяжмалын нийлүүлэлт буурчээ.

Харин үүний эсрэгээр, дэлхийн зах зээл дээр алтны үнэ тогтмол байгаагийн шалтгаан нь алт нь өөрөө давхар валютыг орлож явдаг утгаараа үнэ хадгалаж байдаг юм байна. Хэдийгээр тийм боловч монгол улсын засгийн газар УИХ-с 2006 оны 5 сард баталсан “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль” баталсан байна. Энэ хуулийн заалтад дэлхийн металлын зах зээл дээр зэсийн үнэ 3400 ам.доллар, алны унцын үнэ 850 ам. Доллараас дээш гарсан үед 68% - ын гэнэтийн ашгийн татвар авахаар заагдсан байна. Энэ хуулийг баталсанаар үндэсний алт олборлогч компаниудын сонирхлыг ноцтой зөрчсөн явдал болсон юм. Энэ хуулийг гарснаар алт олборлогч олон жижиг аж ахуйн нэгжүүд дампуурч, зарим хэсэг нь татварын дарамт багатай салбарт шилжисэн бол нөгөө талаар хууль бус арилжаа газар авч энэ төрлийн гэмт хэргийн сүлжээ үүсч улмаар далд эдийн засагт шилжээд байна. Дээрх сөрөг үр дагавараас улбаалан салбарын хөрөнгө оруулалт багасаж тодорхой хэмжээнд улсын төсөвт оруулж байсан орлого буурсан байна.

«Гэнэтийн ашгийн татварын хууль» батлагдахаас өмнө буюу 2005 онд Монгол улсад алт олборлогч аж ахуйн нэгж байгууллага хувь хүмүүс 24.1 тн алт олборлож байсан бол 2006 онд 22.5 тн, 2007 онд 17.4 тн, 2008 онд 12.5 тн болж тус тус буурсан байна. Мөн Гаалийн ерөнхий газрын мэдээгээр 2005 онд 23.8 тн, 2006 онд 15.4 тн, 2007 онд 11.6 тн алт экспортлосон байна. Мөн хувиараа алт олборлогч нар улсын эрдэнэсийн санд 2005 онд 1723 кг алт тушааж байсан бол хууль батлагдсанын дараа 223кг болж буурсан байна. Сүүлийн 3 жилийн дотор монгол улсын эрдэнэсийн санд тушаагдсан алтны хэмжээ хууль батлагдсанаас хойш 40-60% хүртэл буурсан мэдээлэл байгаа юм.

Үүнээс улбаалан энэ салбарын хөрөнгө оруулалт багасаж улмаар валютын нөөц багасан инфляци өсөх зэрэг макро эдийн засгийн хүчин зүйлүүдэд сөргөөр нөлөөлж байгаа юм. Мөн 2006 онд гадаад худалдааны тэнцэл эерэг гарсан ба түүнээс хойш алдагдалтай гарсан байна. Энэ бүх тоо баримтаас харахад алтны үнэ нөлөөлөөгүй, зөвхөн алтны үнийн өсөлтийн албан татвар нөлөөлсөн харагдаж байгаа юм.

Энэ бүх дотоодын болон дэлхийн эдийн засгийн хямрлын нөлөөнд уул уурхайн салбарын зарим компаниуд барьц алдаж зарим хэсэг нь ажиллах орон тоогоо цомхотгож зарим нь үүд хаалгаа барихад хүрээд байна. Энэхүү санхүүгийн хямралыг хохирол багатай даван туулахын тулд тодорхой бодитой арга сонгож ажиллах хэрэгтэй бөгөөд засгийн газраас мөн уул уурхайн салбарыг дэмжих эдийн засгийн орчинг бүрдүүлэх цаг болсон гэдэг нь харагдаж байна.

4. Хүндрэл бэрхшээлээс гарах арга зам

Өнөөдөр нэгэнт үүсээд байгаа санхүү, эдийн засгийн хямрал нь бидний хувьд бэрхшээл мэт харагдах боловч үүний цаана улс орныхоо хөгжлийг түргэсгэх томоохон боломж бүрдэж байж болох юм.

Энэ бүх хямралыг хохирол багатай даван туулах тодорхой арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй бөгөөд юуны өмнө алт олборлох чиглэлийг бодлогоор дэмжиж хөрөнгө оруулалтыг татах боломжийг хайх хэрэгтэй байна. Дэлхийд нэрд гарсан банк санхүүгийн байгууллагын судалгаагаар алтны ойрын жилийн үнэ харьцангуй өндөр байх төлөвтэй байгаа бөгөөд 1 унци алтны үнэ 900-1000 ам.долларт хүрэх төлөвтэй байна. Энэ байдал дээр тулгуурлан манай алт олборлогч компаниуд тодорхой хэмжээгээр сэргэх боломж гарч байгаа бөгөөд мөн засгийн газраас тодорхой бодит алхам хийж үнийн өсөлтийн албан татварыг тэглэх замаар монгол улсын санхүүгийн чадварыг нэмэгдүүлж, валютын хомсдлоос урьдчилан сэргийлж, улсын төсөвөө ч зузаатгах боломж гарч буй юм. Энэ үнийн өсөлтийн татварыг тэглэснээр алт олборлогчдын санхүүгийн чадвар сэргэж гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэх, байгаль орчинд хор нөлөө багатай шинэ дэвшилтэд технологи нэврүүлэх, ажлын байр шинээр бий болж цалин хөлс нэмэгдэж, валютын нөөц нэмэгдсэнээр төгрөгийн ханш тогтворжих зэрэг эдийн засгийн өсөлтөнд эерэгээр нөлөөлөх олон давуу тал бий болох юм.

Мөн хятадын зах зээлд түүхий эдийг хямдаар экспортлох биш бусад гуравдагч орны зах зээлийг судалж эцсийн бүтээгдэхүүн нийлүүлэх боломжийг судлах хэрэгтэй гэж үзэж байна. Ингэхдээ өнөөдөр үйл ажиллагаа эхлээд байгаа цэвэр зэс гаргах “Эрдмин” үйлдвэрийг өргөтгөх, технологийн өргөтгөл хийх замаар “Эрдэнэт” УБҮ-ийн зэсийн баяжмалыг дотооддоо 100% боловсруулдаг болохыг тэргүүн зэлжинд зорилго болгон хэрэгжүүлэх боломжтой юм. Мөн түүхий нүүрсийг их хэмжээгээр экспортлож байгааг нэн даруй зогсоох шаардлагатай байна. Ашиггүй хольцыг хол зайд тээвэрлэнэ гэдэг эцсийн дүндээ хэрэглэгч, нийлүүлэгчийн аль алинд эдийн засгийн алдагдал болж бууна.

Засгийн газраас гаргасан цогц хөтөлбөр дээр тулгуурлан стратегийн ордуудаа ойрын үед эргэлтэнд оруулж хямрал бэрхшээлээс гарах бас нэгэн гарц байгааг энд тэмдэглэе. Монгол улсад төмрийн хүдрийн 200 гаруй илэрцээс 7 ордын нөөцийг тогтоосон ба дархан-сэлэнгийн бүс нутагт 0.5 тэрбум.тн төмрийн хүдрийн нөөцтэй 4 орд газарт нарийвчилсан хайгуул хийгдсэн бөгөөд эдгээр ордын хүдэр нь сайн чанарын хүдэрт хамаарагдах ба өндөр агуулгатай исэлдсэн хүдрийг нь ширэм, ган үйлдвэрлэлд шууд ашиглах боломжтой гэсэн судалгаа байна. Энэ ордууд дээр түшиглэн уул уурхай - хар металлургийн цогцолбор үйлдвэр барих боломжтой гэсэн тооцоог эрдэс баялаг эрчим хүчний яамнаас гаргасан.

Дэлхий дээр 43 орон ураны нөөцтэй гэж бүртгэгдсэн байдгаас монгол улс жагсаалтын 13-т бичигдсэн байна. Одоогоор 60.0 мянган тн ураны нөөцтэй гэж тогтоогдсон судалгаа шинжилгээний, хайгуулын ажилгааг эрчимтэй хийвэл нөөцөөрөө эхний 10 т ч орох боломжтой гэж үздэг байна. Одоогоор бүртгэгдсэн стратегийн ач холбогдол бүхий 15 ордын Мардай, Дорнод, Гурван булаг гэсэн гурван орд нь ураны орд юм. Цөмийн эрчим хүч, техник технологи өндөр хөгжиж буй өнөө цагт улс орныхоо ирээдүйн хэтийн төлөвийг бодсон ч атомын цахилгаан станцтай болохын тулд ураны нөөцөө олборлож ашиглах цаг хэдийн болжээ. Үүнтэй зэрэгцэн гадны хөрөнгө оруулагчид манай ураны салбарыг сонирхон зарим нэг улсууд хамтран ажиллах саналаа тавьж эхэлсэн байна. Монгол улсын ураны нөөцийг судалсан байдлаас үзэхэд тогтоогдсон нөөц нь өөрийн оронд байгуулах станцыг хангаад зогсохгүй өөр атомын цахилгаан станцтай улсуудад экспортлох боломжийн нөөцтэй гэж үздэг юм байна. Харамсалтай нь өнөөдрийн байдлаар уран олборлох боловсруулах талаар монгол улсад хууль эрх зүйн орчин бүрдээгүй, энэ чиглэлээр төрөөс баримтлах бодлого эцэслэн тодорхойлогдоогүй байна.

Манай орны валютын нөөцийг бүрдүүлэгч гол бүтээгдэхүүний эх үүсвэрийн нэг нь яах аргагүй нүүрсний экспортын орлого билээ. Одоогоор монгол улсад нүүрс олборлож буй компаниуд зөвхөн хүрэн нүүрсээ олборлож дотоодын хэрэгцээгээ хангахын зэрэгцээ Хятад улс руу экспортлодог. Стратегийн ач холбогдол бүхий нүүрсний Таван толгой, Нарийн сухайт, Багануур, Шивээ Овоо гэсэн 4 орд байгаагийн 3 нь ашиглагдаж байгаа ба Таван толгойн ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ бэлтгэгдэх шатандаа явж байна.

5. Дүгнэлт

Хүндрэл бэрхшээлээс хамгийн том гарц бол яах аргагүй уул уурхайн салбарын хөгжил гэж тодорхойлж байгаа бөгөөд энэ салбарыг эрчимтэй бодлоготой хөгжүүлсэнээр Монгол улсын эрх ашиг, нэр хүнд, эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийн хөгжингүй орны жишигт хүрэх боломжтой гэсэн тооцоо байдаг. Энэхүү илтгэлээрээ дэлхий нийт санхүү, эдийн засгийн хямралтай байгаа өнөөгийн нөхцөлд манай улсын хөгжлийн тэргүүлэх салбар, Уул уурхайн салбарт хямрал хэрхэн нөлөөлж байгааг өөрийн харснаар тайлбарлахын зэрэгцээ хүндрэлийг яаж даван туулах, өөрт ашигтайгаар хувиргаж болох талаар өөрийн санаагаа гаргахыг зорисноо дараах байдлаар дүгнэн тодорхойллоо. Үүнд:

1. Гадаадын болон дотоодын үйлдвэрлэгчдэд үйл ажиллагаа явуулах хууль эрхзүйн таатай орчинг бүрдүүлэх. Үүн дотроо нэн түрүүнд “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль” буюу «Гэнэтийн ашгийн татварын хууль»-ийн хүчингүй болгож алт, зэсийн үйлдвэрлэл эрхлэгчдийг төрийн бодлогоор дэмжих. Мөн байгаль орчинд хамгийн хоргүй технологиор эрчим хүч үйлдвэрлэх түүхий эд болох цөмийн энергийг түүхий эд ураныг ашиглах талаар төрөөс баримтлах бодлогоо тодорхойлж, энэ талаар мөрдөх хуулиудыг ойрын үед батлан гаргах нь нэн тэргүүнд хийгдэх ажлууд гэж үзэж байна.

2. Үйлдвэрлэл, технологийн салбарт шинэчлэл хийж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилтыг тавьж ойрын үед хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Нэг ч тонн зэсийн баяжмал, нэг ч тонн түүхий нүүрс экспортлодоггүй болох нь бидний эцсийн зорилго. Мөн үүн дээр газрын тосны бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг яаралтай

3. Дээр дурьдсан стратегийн ач холбогдол бүхий ордууд дээрээ түшиглэн эрчим хүч, авто зам, төмөр зам, усан хангамж зэргийг шийдсэн, соёл нийгмийн болон боловсролын асуудлыг шийдсэн дэд бүтцийг өндөр хөгжүүлсэн шинэ хот суурин байгуулах нь чухал юм. Мөн санхүүгийн болон технологийн чадавхитай гуравдагч зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулан өндөр өгөөж авчирч чадах байгаль орчныг хамгаалах болон аюулгүй ажиллагааны өндөр туршлага чадвар бүхий шилдэг хөрөнгө оруулагчийг сонгон авч хамтран ажиллах хэрэгтэй бөгөөд төрөөс энэ салбарын хөгжилд нэмэр болохуйц эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэн оновчтой хууль тогтоомжийг ард иргэдийнхээ өмнө ил тод батлах нь юу юунаас илүү чухал болоод байна.

Эдгээр хөрөнгө оруулагч нарыг сонгохдоо олон улсад нэр хүнд бүхий зөвлөгөө үзүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж төрийн оролцох хувь хэмжээг илүү тусгасан сайн гэрээ хэлэлцээр хийх хэрэгтэй байна. Мөн гаднаас авч буй зээл тусламж дээрээ тулгуурлан дотоодын үйлдвэрлэгч компаниудаа дэмжих зөвхөн дотоодын үйлдвэрлэгч нарт зориулсан татварын таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал:

1. mining.mn
2. mrpam.gov.mn
3. nso.mn
4. worldbank.org
5. kitko.com
6. lme.co.uk
7. mining.com